





Гарчиг

УДИРТГАЛ.....	0
Судалгааны зорилго, зорилт	0
Судалгааны бэлтгэл ажил, судалгааны аргачлал	1
Судалгааны хамрах хүрээ:	3
Судалгааны түүвэрлэлт	3
Асуулгын бүтэц, боловсруулалт	5
___ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ:.....	26

УДИРТГАЛ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хэрэглэгчийн үнэлгээг “Ажиглалт” ХХК Оюуны өмчийн газартай байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэсэн. Хэрэглэгчийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг удирдлага болгон хийсэн болно.

Энэхүү Хэрэглэгчийн үнэлгээний зорилго нь Оюуны өмчийн газраас хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд чиглэсэн бодлого, шийдвэр чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход оршино. Тухайн зорилгын хүрээнд тус байгууллагын бодлого, үйл ажиллагаа иргэдэд хэрхэн хүрснийг үнэлэн, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар иргэдийн саналыг судалж, иргэдээс авсан санал асуулгын дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэж байна.

Хэрэглэгчийн үнэлгээний ажлын удирдамжийг боловсруулахдаа Оюуны өмчийн газрын онцлог, хамарч буй хүрээ, бодлогын хүртээмжтэй байдлыг анкетын санал асуулга, ярилцлагын арга, харьцуулалтын аргыг хэрэглэн үнэлэхийг зорьсон бөгөөд статистик болон тоон мэдээлэл цуглуулсан болно. Хүн амын дотор насанд хүрсэн иргэдийн 5 хувиар бодож Нийслэлийн 6 дүүргийн 860 гаруй иргэдээс төрийн үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэсэн болно.

Түүнчлэн 96 төрийн албан хаагчаас Оюуны өмчийн байгууллагын үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэсэн. Мөн анкетын судалгааны зарим асуулгыг чанар\ярилцлагын\-ын судалгаагаар баталгаажуулсан. Чанарын судалгааг иргэн, төрийн албан хаагч, судлаачдыг оролцуулан 8 хүнтэй ярилцлага хийсэн ба зарим иргэдтэй фейсбүүк чаатаар харилцаж, ярилцлага авсан болно.

Судалгааны зорилго, зорилт

Оюуны өмчийн байгууллага түүний хамтран ажилладаг байгууллагуудын зүгээс иргэд олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг үнэлүүлэх, санал авах, үндсэн бодлого үйл ажиллагааг сайжруулахад судалгааны зорилго оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан болно. Үүнд:

1. Оюуны өмчийн байгууллагын үйл ажиллагаа, мэдээлэл сурталчилгааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийг үнэлэх

2. 2023 онд иргэдэд чиглэсэн гол төсөл, хөтөлбөр болон нэвтрүүлгийн талаарх мэдээлэл, үнэлгээг тодорхойлох

3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, албан хаагчдын харилцаа, ёс зүй, үйлчилгээний орчны талаарх иргэдийн сэтгэл ханамжийг үнэлэх



4. Төрийн үйлчилгээний талаарх мэдээллийн суваг, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах саналыг тодорхойлох зорилтуудыг дэвшүүлсэн болно.

Судалгааны бэлтгэл ажил, судалгааны аргачлал

Оюуны өмчийн байгууллагын үйл ажиллагаа, түүний чанар хүртээмжийг судалж, түүнд иргэдийн сэтгэл ханамж хэр байгааг тодорхойлохын тулд анкетын санал асуулгыг мэргэжлийн түвшинд бэлтгэж, дүгнэлээ. Өөрийн байгууллагын судлаачдын хүчийг ашиглахын зэрэгцээ мэргэжлийн судалгааны ажилтантай гэрээ байгуулан ажиллаа.

Судалгааны аргачлал:

Тоон судалгаа: Анкетын судалгаа

Чанарын судалгаа: Анкет ярилцлага

Суурь судалгааны хүрээнд: Бичиг баримтын 2 төрлийн судалгааг хийж гүйцэтгэсэн.

Анкет

Нийслэлийн 6 дүүргийн судалгаанд оролцсон иргэд /Төрийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа - А/, төрийн албан хаагчид болон бусад байгууллагын ажилтан албан хаагчид, хуульчдаас/Төрийн үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн судалгаа - Б Оюуны өмчийн байгууллагад хэрэгжиж буй хөтөлбөр, үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байгаа эсэх, харьяа байгууллагын үйлчилгээнд өгч буй үнэлгээ, тус байгууллагын үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл, шалтгаан, хүчин зүйлийг шинжлэн судлахад чиглэгдсэн. Анкетын судалгааны асуумжид захиалагч талын санал зөвлөмжийг тусгасны зэрэгцээ арга зүйн хувьд харьцуулан судлах, боловсруулах боломжтой, цаашид авч хэрэгжүүлэх бодлого шийдвэрүүдэд тусгаж болохуйц асуултуудыг оруулсан болно.

Ганцаарчилсан ярилцлага

Судалгаанд хамруулахаар сонгосон экспертүүдэд Оюуны өмчийн газартай чиг үүргээ хэрхэн гүйцэтгэж байгаа тал дээр үнэлэлт дүгнэлт авч анкетын судалгааг чанаржуулах, ганцаарчилсан ярилцлагаар тоон судалгаанаас төдийлөн гарах боломжгүй, тухайн салбартай холбоотой асуудлыг илрүүлэн гаргахыг зорьсон. Экспертүүдтэй хийх ярилцлагын үед оролцогчид асуудлыг олон талаас тодруулах, шалтгаан нөхцөлийг илүү гүнзгий тайлбарлах боломжтой байдаг.

Баримт бичгийн судалгаа

Оюуны өмчийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэхийн тулд холбогдох статистик мэдээлэл, үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлт, одоо хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр болон үйлчилгээтэй холбоотой ирсэн гомдол, мэдээлэл, байгууллагын цахим хуудасны мэдээлэл болон холбогдох бусад баримт бичгүүдийг цуглуулан дүн шинжилгээ хийв.



Хүснэгт 1. Суурь болон ажиглалтын судалгаа

д/д	Судалгааны багц	Судалгааны төрөл	Түүвэр дэх шалгуур
1.	Суурь судалгаа	Асуулга судалгаа	Сонгосон дүүргийн иргэд, төрийн албан хаагчид
		Анкет ярилцлага	Асуулгын асуултыг илүү нарийвчилсан байдлаар алба хаагчид болон экспертүүд, иргэнээс учир шалтгааныг тодруулсан нэмэлт тодруулга авсан
2.	Ажиглалтын судалгаа	Цахим хуудасны шинжилгээ	Цахим хуудсанд тодорхой шалгуураар үнэлгээ хийх

Хэрэглэгчийн итгэл үнэмшлийн үнэнч байдлыг хэмжих зорилгоор “Оюуны өмчийн байгууллагаас иргэдэд үзүүлсэн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдал өмнөх жилтэй харьцуулахад хэр их ахиц гарсан бэ?”, -10 оноо, огт санал болгохгүй-0 буюу 0-10 онооноос сонголт хийлгэсэн.

Хариултын онооноос шалтгаалан хэрэглэгчийг гурван түвшинд авч үзсэн. Үүнд:

1. Дэмжигч хэрэглэгч (9-10 оноо)
2. Эргэлзэгч хэрэглэгч (7-8 оноо)
3. Үл итгэгч (0-6 оноо)

Үр дүнг дэмжигч хэрэглэгч /9-10 оноо/-ийн хувиас үл итгэгч хэрэглэгч /0-6 оноо/-ийг хасаж хэрэглэгчийн өсөлт, үнэнч байдлыг тооцсон. Үнэнч байдлын утга сөрөг тэмдэгтэй гарч болно. Энэ нь сөрөг мэдээллийн итгэгдэх байдал, бусдад мэдээллийн тархах байдал илэрхийлсэн хувиар тарах магадлал байгааг харуулна.

Зураг 2. Хэрэглэгчийн түвшин (NPS)





Судалгааны хамрах хүрээ:

Түүврийн харьцааг 70:30 байхаар тооцсон бөгөөд судалгаанд оролцсон иргэдийн 68% нь УБ хотын иргэд, 32% нь төрийн албан хаагч байгаа тул түүврийн бүтэц хангагдсан гэж үзэж байна.

Хэрэглэгчийн үнэлгээний анкетын судалгаанд 389 иргэн хамрагдсан. Төрийн байгууллагын төлөөлөл болон хуульчдаас авах асуулгад 95 хүн оролцсон. Мөн экспертийн түвшинд судлаач 3 үүнээс PhD 2, төрийн албаны удирдах болон ахлах ажилтан, иргэд, нийт 8 хүнтэй ярилцлага хийх замаар чанарын судалгааг авсан болно.

Оюуны өмчийн байгууллагын цахим хуудаст шинжилгээ хийж, иргэд мэдээлэл авах боломжоор хангагдсан эсэхийг судалж цаашид авах арга хэмжээний зөвлөмжийг гаргасан.

Судалгааны түүвэрлэлт

Судалгааны түүвэрлэлтийг хийхдээ эх олонлогийг хэвийн тархалттай гэж үзэн энгийн санамсаргүй түүврийн аргыг ашигласан. Түүврийн хэмжээг тогтоохдоо дараах томъёог ашиглав.

$$n = \frac{t^2 * w * (1 - w) * N}{N * \Delta_p^2 + t^2 * w * (1 - w)}$$

Түүврийн хэмжээ 95%-ийн итгэх магадлалтай, +/- 5%-ийн алдааны хязгаартай байхаар тооцож, оновчтой түүврийг 389 хүн гэж тогтоов. Төрийн албан хаагч хуульчийн хувьд түүврийг 96 хүн гэж тооцов.

Хүснэгт 2. Түүврийн бүтэц

Аймаг, нийслэл	Иргэд			Алба хаагчид		
	Дүүрэг	Тоо	Хувь	Байгууллага	Тоо	Хувь
УБхот	БГД	43	11%	ХЗДХЯ	21	22%
УБ хот	БЗД	55	12%	ХНХЯ	11	12%
УБ хот	СБД	43	11%	Соёлын яам	30	31%
УБ хот	СХД	47	12%	ГХЯам	16	16%
УБ хот	ХУД	39	10%	УУХУЯам	7	7%
УБхот	ЧД	52	11%	Бусад	10	9%
ХЗДХЯ		36	7%	Нийт	95	97%
ХЭҮК		45	9%			
МӨХолбоо		59	15%			
Нийт		379	88%			



Алба хаагчдын судалгаанд 95 хүн хамрагдсан, 48% нь эмэгтэй, 52 хувь нь эрэгтэй, насны хувьд 41% нь 36-45 настай, 29% нь 46-аас дээш настай, 27% нь 26-35 настай, 2% нь 18-25 настай албан хаагчид оролцжээ. Боловсролын хувьд 52% нь магистр 42% нь бакалавр, 5% нь доктор, 1% нь бүрэн дунд боловсролтой байна.

Хүснэгт 3. Судалгаанд оролцсон төрийн албан хаагчийн хүн ам зүйн мэдээлэл

Асуулт	Хариулт	Тоо	Хувь
Насны бүлэг	18-25 нас	2	2%
	26-35 нас	26	27%
	36-45нас	39	41%
	46-аас дээш	28	29%
	Нийт	95	100%
Хүйс	Эмэгтэй	46	48%
	Эрэгтэй	49	52%
	Нийт	95	100%
Боловсрол	Бүрэн дунд /10/11/12 анги/	1	1%
	Дээд /Бакалавр/	40	42%
	Дээд /Доктор/	5	5%
	Дээд /Магистр/	49	52%

Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд 389 хүн хамрагдсанаас 10 анкет хүчингүй болж 379 иргэн хамрагдсан. Үүний 61% нь эмэгтэй, 39% нь эрэгтэй, насны бүлгээр харвал 11% нь 18-25 настай, 25% нь 26-35 настай, 36% нь 36-45 настай, үлдсэн 29% нь 46-аас дээш настай иргэд байна. Боловсролын хувьд 78% нь дээд, 13% нь бүрэн дунд, 4% нь дунд 3% нь Суурь /11-12 анги/ боловсролтой, үлдсэн 2% нь боловсролгүй/бага гэсэн ангилалд хамаарагдаж байна.

Ажил эрхлэлтийн байдлыг харвал 90% нь ажил хөдөлмөр хийдэг, үүний 40% нь төрийн байгууллагад ажиллаж байна. Ажилгүй иргэд 8%-ийг эзэлж байна.

Хүснэгт 4. Судалгаанд оролцсон иргэдийн хүн ам зүйн мэдээлэл

Асуулт	Хариулт	Тоо	Хувь
Насны бүлэг	18-25 нас	40	11%
	26-35 нас	93	25%
	36-45 нас	136	36%
	46-с дээш	110	29%
	Нийт	379	100%
Хүйс	Эмэгтэй	230	61%
	Эрэгтэй	149	39%
	Нийт	379	100%
Боловсрол	Боловсролгүй /бага	6	2%



	Суурь /8, 9 анги/	13	3%
	Бүрэн дунд	49	13%
	Дунд	16	4%
	Дээд	295	78%
	Нийт	379	100%
Ажил эрхлэлт	Ажилгүй	31	8%
	Төрийн байгууллага	151	40%
	ТББ/Олон улсын байгууллага	20	5%
	Хувийн хэвшил, компани	72	19%
	Хувиараа бизнес эрхэлдэг	42	11%
	Бусад	53	14%
	Хариулаагүй	10	3%
	Нийт	379	100%

Асуулгын бүтэц, боловсруулалт

Оюуны өмчийн байгууллагын 2023 оны Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны асуулгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тогтоолоор батлагдсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг үндэслэл болгон боловсруулсан. Анкетын судалгаа – А нийт зургаан бүлэг 72 асуулттай. Судалгааг мэдээллийг IBM SPSS 23.0 программ ашиглан боловсруулав.

Хүснэгт 5. Анкетын асуулгын бүтэц /Анкет -А/

Бүлэг	Асуултын тоо	Агуулга
Нэгдүгээр бүлэг	16 асуулт	Оюуны өмчийн байгууллагын үйл ажиллагаанд өгсөн ерөнхий сэтгэл ханамжийн үнэлгээ, иргэдийн оролцоо, мэргэжил арга зүйн түслалцаа хэр үзүүлдэг, техник технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа хэр ашигладаг, албан хаагчид авлигаас ангид шударга ажиллаж байгаа байдал, үйл ажиллагааны шуурхай байдал, албан хаагчдын харилцаа хандлагын үнэлгээ, санал, гомдолд хариу өгөх байдал зэрэгт өгөх үнэлгээ
Хоёрдугаар бүлэг	8 асуулт	Оюуны өмчийн байгууллагад өгөх сэтгэл ханамжийн үнэлгээ, бодлого шийдвэрүүд хэр ил тод нээлттэй байгаа, эдгээр байгууллагуудын талаарх мэдээлэл, үйл ажиллагааны үнэлгээ, шуурхай байдал, ажилтнуудын харилцаа хандлага, санал гомдолд хариу өгөх байдал, залгамж холбоо зэрэг асуудлын үнэлгээ
Гуравдугаар бүлэг	7 байгууллагын талаарх 6 асуулт	Үйл ажиллагааны хэрэгжилт үр дүн, ил тод нээлттэй байдал, авлигаас ангид шударга байдал, түргэн шуурхай байдал, ажилтан албан хаагчдын харилцаа, хандлага, гадна, дотно тохижилт, үйлчилгээний ая тухтай орчинг бүрдүүлсэн байдлын үнэлгээ
Дөрөвдүгээр бүлэг	22 асуулт	Хууль, дүрэм журам хүн бүрт тэгш үйлчилж байгаа эсэх, хуулийн төсөлд хэр оролцдог, иргэд Оюуны өмчийн үйл ажиллагаанд хэр хяналт тавьж байгаа;
Тавдугаар бүлэг	14 асуулт	Үйлчилгээний чанар хүртээмж, албан хаагчдын харилцааны соёл, ёс зүй болон үйлчлүүлсэн байгууллагын орчны үнэлгээ, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдлын өмнөх жилтэй харьцуулсан ахицын үнэлгээ, Оюуны өмчийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахын тулд хүсч буй ажил болон өмнөх жилээс үр дүнтэй ажлыг үнэлэх
Зургадугаар бүлэг	5 асуулт	Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээлэл

Анкетын судалгаа – Б нийт дөрвөн бүлэг 55 асуулттай. Судалгааг мэдээллийг IBM SPSS 23.0 программ ашиглан боловсруулав.

**Хүснэгт 6. Анкетын асуулгын бүтэц /Анкет -Б/**

Бүлэг	Асуултын тоо	Агуулга
Нэгдүгээр бүлэг	6 асуулт	Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл
Хоёрдугаар бүлэг	16 асуулт	Оюуны өмчийн байгууллагын үйл ажиллагаанд өгөх үнэлгээ, үйл ажиллагааны нээлттэй байдал, техник, технологийн дэвшилийг үйл ажиллагаандаа хэр хэрэглэдэг, авлигаас ангид, шударга байдлын үнэлгээ, үйл ажиллагааны шуурхай байдал, ажилтан албан хаагчдын харилцаа, хандлага, гомдолд хариу өгөх байдлын үнэлгээ
Гуравдугаар бүлэг	7 байгууллагын 6 асуулт	Оюуны өмчийн байгууллагад өгөх үнэлгээ, үйл ажиллагааны хэрэгжилт үр дүн, ил тод нээлттэй байдал, авлигаас ангид шударга байдал, түргэн шуурхай байдал, ажилтан албан хаагчдын харилцаа хандлага, гадна дотно тохижилт үйлчилгээний ая тухтай байдлыг бүрдүүлсэн байдал зэрэгт үнэлгээ хийх
Дөрөвдүгээр бүлэг	27 асуулт	Иргэдийн оролцоо, аюулгүй байдал, хууль, дүрэм журам хүн бүрт тэгш үйлчилж байгаа эсэх

Судалгааны ажлын зохион байгуулалт

Судалгааны ажил нь гэрээний дагуу цахим сүлжээний сүүлийн үеийн дэвшилтэд технологийг ашиглах замаар цахим болон бусад хэлбэрээр амжилттай хийж гүйцэтгэсэн. Тоон судалгааны мэдээллийг 2023 оны 10 дугаар сарын 05-наас асуултыг боловсруулан 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртлэх хугацаанд хийж гүйцэтгэсэн. Чанарын судалгааны мэдээллийг 2023 оны 10 сарын 05-наас 10 сарын 20-ны өдрүүдэд ярилцлагын аргыг ашиглан цуглуулсан.

НЭГ. ОЮУНЫ ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН ҮЭНЛЭГЭЭ

Тус байгууллага нь 2023 онд Оюуны өмчийн тогтолцоог хөгжүүлэх үндэсний стратегийн зорилго нь иргэдийн бүтээл түүрвэх, шинийг санаачлах үйл ажиллагааг дэмжих, оюуны өмчийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгон оюуны өмчийн ашиглалтыг нэмэгдүүлэх замаар мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох, дэлхийн эдийн засагт эзлэх Монгол улсын байр суурийг нэмэгдүүлэхэд оршино гэсэн зорилготойгоор 6 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт заасан Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд тавигдаж байгаа байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд цогц шинжилгээ хийлгэн үнэлэлт дүгнэлт гаргуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, хүнд сурталгүй, цомхон чадварлаг төрийн албыг бүрдүүлэх зорилт, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор Оюуны өмчийн газрын үйл ажиллагаанд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлыг албан ёсоор эхлүүлсэн байна.



Оюуны өмчийн газар Чанарын менежментийн тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлыг уг олон улсын стандартыг төр, хувийн хэвшлийн 80 гаруй байгууллагад амжилттай нэвтрүүлсэн байна.

Олон улсын стандартыг нэвтрүүлснээр тус газраас үзүүлж байгаа төрийн үйлчилгээ үзүүлэх процесст тавих хяналтын тогтолцоо сайжирч, байгууллагын үйл ажиллагааг харилцагч, хэрэглэгч, иргэд үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг системтэйгээр хянах, иргэдийн сэтгэл ханамжийн баталгааг хангах улмаар төрд итгэх итгэлийг сэргээх ач холбогдолтой болно.

Зорилт-1“Оюуны өмчийн эрх зүйн орчныг монгол улсын хөгжлийн шаардлага, олон улсын чиг хандлагад нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд:

Оюуны өмчийн биет бус хөрөнгийн үнэлгээний аргачлалыг Оюуны өмчийн газрын даргын 2022 оны А/44 дүгээр тушаалаар ажлын хэсгийг байгуулан Мэргэшсэн үнэлгээчдийн институттэй хамтран оюуны өмч, биет бус хөрөнгийн үнэлгээний аргачлалын төслийг боловсруулан Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн холбооноос санал авч байна.

Барааны тэмдгийн бараа, үйлчилгээний олон улсын ангиллын үндсэн жагсаалтын нэмэлтэд хамаарах 52574 нэр томъёог орчуулж, ДООБ-ын холбогдох газарт 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр ives.close@wipo.int цахим шуудангаар хүргүүлээ.



Зорилт-2 “Бүтээл туурвих, шинийг санаачлах, үйл ажиллагааг дэмжих тогтолцоог боловсронгуй болгох” зорилтын хүрээнд:

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөвлөлийн 2023 оны анхдугаар хуралдаан 4 дүгээр сард хуралдаж, 2023 оны ажлын төлөвлөгөөг баталлаа. Мөн хамтын удирдлагын байгууллагаас санал болгож байгаа зохиогчийн эрхийн бүтээл ашиглуулах гэрээний тарифыг мөрдөж ажиллах тухай тогтоолд санал авч баталлаа.

Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд баримтлах журмын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр Монголын хөгжмийн зохиолч, нийтлэгчдийн нийгэмлэгтэй хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулж, хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд баримтлах журамд заасны дагуу үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бүтээлийг ашиглуулахаар байгуулсан гэрээний мэдээлэл, гишүүдэд тайлан тавьсан тухай хурлын тэмдэглэлийг Монголын зохиолч, хөгжмийн зохиолч, нийтлэгчдийн нийгэмлэгээс 2023 оны 23/019 дугаар албан бичгээр тус газарт ирүүлсэн.

Оюуны өмчийн статистик мэдээг Монгол Улсын албан ёсны статистик мэдээнд 2022 оны жилийн эцсийн статистик мэдээг 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор нэгтгэж хүргүүллээ.

Аж үйлдвэрийн өмчийн статистик мэдээг 2023 оны 05 дугаар сарын 23-ний өдөр Дэлхийн Оюуны өмчийн байгууллагын ipstats.mail@wipo.int цахим шууданд илгээлээ.

Оюуны өмчийн газрын ipom.gov.mn вэб сайтад байршиж буй “Оюуны өмчийн лицензийн бүртгэлийн мэдээллийн систем”-д ашигтай загварын 65, барааны тэмдгийн 88, бүтээгдэхүүний загварын 9, шинэ бүтээлийн 84 нийт 246 лицензийн гэрээний бүртгэлийг цахимжуулж, мэдээллийг орууллаа.

- Аж үйлдвэрийн өмчийн удирдлагын IPAS(Version:3.6.1C) систем
- Аж үйлдвэрийн өмчийн Цахим мэдүүлгийн Efiling(Version:2.4.0A) систем
- Аж үйлдвэрийн өмчийн хайлтын систем IPOMPublish(Version:1.5.)

IPAS системийг Cloud технологи руу шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах Дэлхийн Оюуны өмчийн байгууллагаас IPAS системийн хэрэглэгч орнуудын дунд 2023 оны 02 дугаар сарын 21-нээс 24-ний өдрүүдэд Сингапур улсад зохион байгуулсан “Дижитал төрийн үйлчилгээний мэдээллийн технологийн бизнесийн стратеги”-ийн семинарт Оюуны өмчийн газрын 3 албан хаагч оролцож, үйл ажиллагаанд ашиглаж буй Аж үйлдвэрийн өмчийн удирдлагын IPAS 3.6.1C, Аж үйлдвэрийн өмчийн цахим мэдүүлгийн систем Efiling буюу WIPO File 2.2, Аж үйлдвэрийн өмчийн хайлтын систем IPOM Publish 1.5.2 хувилбарын ашиглалт, гарч буй асуудал, шийдвэрлэлт, шинэчлэлт, хөгжүүлэлтийн талаар мэдээлэл солилцлоо.



Мөн Дэлхийн Оюуны өмчийн байгууллагын IPAS төслийн менежер Mr.Kyaw Zuaw-тай онлайн уулзалт хийж Cloud технологит шилжүүлэхэд урьдчилсан байдлаар хийгдэх ажлын төлөвлөгөөг гарган танилцуулж, холбогдох бэлтгэл ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэж байна.

Албаны хэрэгцээнд ашиглаж буй программ хангамжийг лицензжүүлэх судалгааг хийж, техникийн даалгаврыг боловсруулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулаар ажиллаж байна.

Зорилт-3 Оюуны өмчийн ашиглалтыг нэмэгдүүлэн үйлдвэрлэлд нэвтрүүлэх, оюуны өмчийн эрхийн хамгаалалтын чанарыг сайжруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах хүрээнд:

Лицензийн гэрээ болон оюуны өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээг бүртгэх Барааны тэмдгийн 13 лицензийн гэрээг бүртгэж, шинэ бүтээлийн патентын 85 мэдүүлэг хүлээн авч, бүрдлийг хянаж, цахимжуулаа. Үүнд:

- Дотоодын иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 43 мэдүүлэг;
- Патентын хамтын ажиллагааны гэрээ (PCT)-ний дагуу гадаадын иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 42 мэдүүлэг;

Тайлангийн хугацаанд бүрдлийн шүүлт хийсэн 72 мэдүүлэгт нэмэлт ;

- Патентын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт заасны дагуу шинэ бүтээлийн 40 патент олгосон байна. Бүтээгдэхүүний загварын нийт 113 мэдүүлэг хүлээж авч, бүрдлийг хянаж, цахимжуулсан. Бүтээгдэхүүний загварын олон улсын бүртгэлийн тухай Гаагийн хэлэлцээрийн дагуу Монгол Улсын нэр заасан гадаадын 54 мэдүүлэг байна. Нийт 110 мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийснээс 24 мэдүүлэгт патент олгохоос татгалзсан тухай урьдчилсан мэдэгдэл гарч, 68 бүтээгдэхүүний загварт Патент олгох тухай шинжээчийн дүгнэлт гарч, нийтэд мэдээлсэн ба 18 мэдүүлэгт патент олгохоос татгалзсан байна.

Гаагийн хэлэлцээрийн дагуу 54 бүтээгдэхүүний загвар бүртгэж, Патентын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт заасны дагуу бүтээгдэхүүний загварын 62 патент олгосон байна. Ашигтай загварын 45 мэдүүлэг хүлээж авч, бүрдлийг хянаж, цахимжуулсан.

Нийт 41 мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийснээс 25 ашигтай загварт патент олгож, 7 мэдүүлэгт патент олгохоос татгалзсан, 9 мэдүүлэгт нэмэлт өөрчлөлтийн мэдэгдэл гаргасан байна.

Барааны тэмдэг газар, зүйн заалтыг бүртгэх, эрхийн хамгаалалт олгох нийт 1612 мэдүүлэг хүлээн авснаас:

-дотоодын болон гадаадын иргэн хуулийн этгээдээс шууд мэдүүлгээр ирүүлсэн 1048,

-Мадридын хэлэлцээр, Протоколын дагуу гадаадын иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн 564 мэдүүлэг байна.



Нийт 2517 мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийснээс 1644 барааны тэмдгийг бүртгэж, нийтэд мэдээлсэн ба 201 барааны тэмдгийг бүртгэхээс татгалзсан тухай эцсийн шийдвэр гаргасан ба 672 мэдүүлэгт урьдчилсан татгалзах шийдвэр гаргаж, мэдүүлэг гаргагчдад хүргүүлсэн байна.

Сайн дурын бүртгэл хөтлөх журмын хэрэгжилтийг хангаж, Зохиогчийн эрхийн бүтээлийг бүртгэх, гэрчилгээг Шинжлэх ухаан, утга зохиолын бүх төрлийн аман болон бичмэл бүтээл -221, хөгжмийн урлагийн үгтэй болон үггүй бүтээл-39, дүрслэх урлаг, уран баримал, график урлагийн бүтээл-36, уран барилга, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, цогцолбор болон архитектурын бусад бүтээл-1, гэрэл зургийн болон түүнтэй төсөөтэй аргаар туурвисан бүх төрлийн бүтээл-1, кино урлагийн болон дуу авиа бүхий дүрст бүтээл-20, компьютерын программ-74, үүсмэл бүтээл-4, мэдээллийн сан -2, материалыг нь сонгон түүвэрлэх, байршуулах зэргээр бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон, өөрийн бүтэц агуулгаараа бүтээлд тооцогдох тайлбар толь, лавлах, зохиолын цоморлог, түүвэр зохиол болон эмхэтгэл-51 зэрэг нийт 449 зохиогчийн эрхийн бүтээлийг бүртгэж, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 16 хүсэлтийн дагуу 31 гэрчилгээ дахин олгох асуудлыг шийдвэрлэж, Зохиогчийн эрхийн газраас 2023 оны хагас жилийн байдлаар нийт 480 зохиогчийн эрхийн гэрчилгээ олгосон.

Оюуны өмчийн газарт 2023 оны эхний хагас жилийн байдлаар 191 өргөдөл, хүсэлт ирүүлсний 189 нь бичгээр, 11-11 төвд 3 хүсэлт ирсэн. Нийт өргөдөл гомдлын 92.6 хувь буюу 177 өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэж, хариуг хүргүүлж, 7.4 хувь буюу 8 өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэсэн байна.

Тус газрын үйл ажиллагаа болон албан хаагчдын ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол бүртгэгдээгүй байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Монголын уран зургийн галерей, Үндэсний урлагийн их театр, Улсын филармони, Чингэлтэй дүүргийн Соёлын ордон, Баянзүрх дүүргийн Соёлын ордон, “Тэнгис” кино театр Өргөө 1” кино театр нийт 7 байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг Соёлын яамтай хамтран хийлээ.

[Зорилт-4 Байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг олон улс, бүс нутаг, гадаад орны түвшинд хөгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах хүрээнд:](#)

Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын оюуны өмчийн байгууллагуудын хамтарсан зөвлөгөөнийг Монгол Улсын оюуны өмчийн газар 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр “Оюуны өмчийн үнэлгээ, зохицуулалт, туршлага” сэдвийн хүрээнд зохион байгуулж, зөвлөлдөх уулзалтаар хэлэлцсэн асуудалтай холбогдуулан Оюуны өмчийн газрын даргын А/44 дүгээр тушаалаар Оюуны өмч, биет бус хөрөнгийн үнэлгээний аргачлал боловсруулах ажлын хэсгийг байгуулан Монголын



мэргэшсэн үнэлгээчдийн институттай хамтран боловсруулж, санал авахаар Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбоонд төсөл хүргүүлээд байна.



Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн АНУ-д хийж байгаа албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Оюуны өмчийн газар болон АНУ-ын Патент, барааны тэмдгийн газар хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан байна.

Уг санамж бичигт Монгол улсын талаас Оюуны өмчийн газрын дарга Г.Элбэгсайхан, АНУ-ын талаас АНУ-ын Патент, барааны тэмдгийн газрын дарга Катерин Видал нар гарын үсэг зурлаа.

Санамж бичгийн хүрээнд инновац, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд оюуны өмчийн гүйцэтгэх үүрэг, оюуны өмчийг эзэмших, ашиглах, хамгаалахад чиглэсэн уулзалт, сургалт, семинар зохион байгуулах, оюуны өмчийг олон нийтэд сурталчлах, патент, барааны тэмдгийн шинжээчдийг сургах, харилцан туршлага, мэдээлэл солилцох зэргээр талууд ирэх таван жилийн хугацаанд хамтран ажиллахаар болсон байна.

Женев хотноо 2023 оны 7 дугаар сарын 06-ны өдөр эхэлсэн Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гишүүн улсуудын 64 дүгээр чуулганд Монгол Улсаас НҮБ-ын Женев дэх төв болон олон улсын бусад байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Элчин сайд Д.Гэрэлмаа, Оюуны өмчийн газрын дарга Г.Элбэгсайхан нар оролцсон байна.

Монгол Улс, Европын Холбооны хооронд байгуулсан Түншлэл хамтын ажиллагааны хэлэлцээрийн 27 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллах- Монгол Улс, Европын Холбооны хооронд байгуулсан Түншлэл хамтын ажиллагааны хэлэлцээрийн 27 дугаар зүйлийн хэрэгжилтийн хүрээнд доорх ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна Үүнд:

1. Монгол Улс болон Европын Холбооны “Газар зүйн заалтын тухай хэлэлцээр” байгуулах хэлэлцээний хоёр дахь шатны хурлыг 2023 оны 1 дүгээр сарын 17-ноос 18-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулсан.



2. Мөн уг хэлэлцээрийн хүрээнд НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр уулзалт зохион байгуулсан ба энэ уулзалтаар Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын зөвлөх Стефан Пассаритай “Газарзүйн заалтыг бүртгэх” журмын төслийг боловсруулахад техникийн туслалцаа үзүүлэх тал дээр зөвшилцөлд хүрсэн.

Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай 2022 онд байгуулсан санамж бичгийн хүрээнд Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран оролцогч талууд, эрх эзэмшигчдэд зориулсан газар зүйн заалтын сургалт 2023 оны 3, 4 дүгээр сард Хөвсгөл, Баянхонгор, Хэнтий, Завхан аймгуудад зохион байгуулж, уг санамж бичгийн хүрээнд Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас зохион байгуулсан “Монгол, Орос, Хятадын худалдаа аж үйлдвэрийн танхимуудын худалдаа эдийн засгийн нэгдсэн форум” арга хэмжээнд шинжээч оролцуулж хамтран ажиллаа.

Зорилт-5 Оюуны өмчийн мэдлэгийг нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд:

Оюуны өмчийн тухай холбогдох хууль тогтоомжийн талаар Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-н албан хаагчид болон 9 дүүргийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчидтэй хамтран сургалт зохион байгууллаа. Үүнд:

* Кино урлагийн зөвлөлтэй хамтран соёл урлагийн салбарынханд Оюуны өмч, Зохиогчийн эрх, Оюуны өмчийн зөрчил сэдвээр;

* МУИС-ийн багш судлаачдад Оюуны өмч, Зохиогчийн эрх, Оюуны өмчийн зөрчлийн талаар;

* Аж үйлдвэрийн өмчийн газраас Оюуны өмчийн ерөнхий ойлголт сэдвээр 3 удаагийн сургалт;

* Сэлбэ сургууль, Оюуны өмчийн газар, Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбоо, АНУ-ын элчин сайдын яам, Нийслэлийн боловсролын газар, Сүхбаатар дүүргийн Боловсролын хэлтэс хамтран “Өөрийгөө таньж, ирээдүйгээ бүтээцгээе” аяныг 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 28-ны өдрүүдэд зохион байгуулан тус сургуулийн сурагчдад оюуны өмчийн талаарх үе шаттай сургалт;

* Газар зүйн заалт бүхий бүтээгдэхүүний тодорхойлолтыг шинэчлэх нь сэдэвт сургалтыг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах төсөлтэй хамтарсан сургалт;

* Монголын Хуульчдын холбоотой хамтран “Хуульчийн про боно өдөр 2023”-т оролцон иргэдэд оюуны өмчийн талаарх зөвлөгөө мэдээлэл;

* Монгол Улсын шинжлэх ухааны академитай хамтран “Бүтээлч хандлага, инновацыг эрчимжүүлцгээе” сэдэвт оюуны өмчийн сургалтыг зохион байгууллаа.

МҮХАҮТ-ын Патент, барааны тэмдэг, газар зүйн заалтын газар, Оюуны өмчийн газрын Патент, барааны тэмдгийн хэлтэс хамтран Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Соёл, урлагийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар, Хөвсгөл аймгийн Музей, Политехникийн коллеж, Цагаан-Уул, Бүрэнтогтох, Галт, Улаан-Уул, Ханх, Арбулаг, Түнэл,



Алаг-Эрдэнэ, Тариалан сумдын Засаг дарга, удирдлага, мэргэжилтнүүд, Хөвсгөл аймгийн салбар танхимын гишүүд болон Баянхонгор аймгийн Жижиг, дунд үйлдвэрийн газар, бизнес эрхлэгчдэд Газар зүйн заалт, түүний ач холбогдлын талаар цахим сургалтыг тус тус зохион байгуулсан байна.

Шинээр батлагдсан дүрэм журмыг цахим хуудаст тогтмол шинэчлэн нийт 47 мэдээллийг байршуулж, 5 видео шторк, 12 постер бэлтгэн нийтэд түгээсэн байна.

Оюуны өмчийн газрын цахим пэйж хуудсанд хандсан 235 иргэнд мэдээлэл зөвлөгөө, Монгол HD телевизийн “Оргил цаг” мэдээллийн хөтөлбөр, Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн “Өглөө” хөтөлбөрийн зочиноор тус газрын албан хаагчид оролцож Оюуны өмчийн эрхийн чиглэлээр олон нийтэд мэдээлэл хүргэсэн байна.

Дэлхийн оюуны өмчийн өдрийг тохиолдуулан WIPO, СУИС-тай хамтран Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн чиглэлийн сургалтын загвар хөтөлбөр батлах уулзалтыг зохион байгуулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын мэндчилгээ, Оюуны өмчийн талаар ойлголт, мэдээлэл өгөх видео шторкийг Улаанбаатар дэлгэц, Лед интернэйшнл, Блүүберг ТВ, Централ молл худалдааны төвийн лед дэлгэц болон байгууллагын цахим хуудас, “Өглөөний сонин”-д нийтлүүлж олон нийтэд түгээлээ.

Олон нийтийг зохиогчийн эрх, хамаарах эрхийн мэдээллээр хангаж зохиогчийн эрхийн талаар сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах- Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн чиглэлээр Кино урлагийн зөвлөл, МУИС, Эрдэм их сургууль, Үндэсний номын сан, Улаанбааиар их сургууль зэрэг хуулийн этгээдүүдэд сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа тогтмол явуулж байна.



Дэлхийн оюуны өмчийн өдрийг тохиолдуулан Оюуны өмчийн газар, Сүхбаатар дүүргийн "Сэлбэ" сургууль, Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбоо, АНУ-ын элчин сайдын яам Нийслэлийн боловсролын газар, Сүхбаатар дүүргийн боловсролын хэлтэс, Монголын сансрын технологийн холбоо хамтран 2023 оны 4 дүгээр сарын 5-аас 28-ны өдрүүдэд “Өөрийгөө таньж, ирээдүйгээ бүтээцгээ” аянг зохион байгууллаа.



"Сэлбэ" сургууль нь суралцагчдынхаа бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх инновацын хичээлийг сургалтын хөтөлбөртөө багтаан заадаг бөгөөд уг аяны хүрээнд ахлах ангийн 8 багийн суралцагчид тулгарч буй асуудлаа шийдвэрлэх зорилгоор инновацын шийдлийг шингээсэн бүтээлүүдээ танилцуулсан ба Оюуны өмчийн газар, Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбооны төлөөлөгчид оюуны өмчийн талаарх үе шаттай сургалт зохион байгуулан, бүтээлээ хэрхэн хамгаалуулах талаар зөвлөгөөг өглөө.

Аяны хүрээнд бага, дунд ахлах суралцагчдын насны ангилалд тохируулан сонирхолтой хэлбэрээр оюуны өмчийн талаарх хичээлийг үзүүлсэн. Хаалтын үйл ажиллагааны үеэр 2022 оны хичээлийн жилд зохион байгуулсан эхний аяны үр дүн болох Ашигтай загварын 2 бүтээлийн патент, Барааны тэмдгийн 3 гэрчилгээг бүтээл хийсэн суралцагчдад гардууллаа.

Ерөнхий боловсролын сургуулийн зарим хичээлийн агуулгад багтсан оюуны өмчийн талаарх /зохиогчийн эрх, аж үйлдвэрийн өмч/ мэдээллийг сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохируулан ойлгомжтой хэлбэрт оруулж, нэмэгдүүлэх талаар судалгаа хийж, БШУЯ-нд санал хүргүүлэх.- Ерөнхий боловсролын сургуулиудад ашиглагдаж байгаа сурах бичигт оюуны өмчийн мэдлэг олгох агуулга багтсан эсэхэд судалгааг хийсэн. ЕБС-иудад ашиглагдаж байгаа сурах бичиг, сургалтын хөтөлбөрт оюуны өмчийн мэдлэг олгох агуулгыг оруулахад хамтран ажиллах хүсэлтийг гаргаж, судалгааны дүнгийн хамт БШУЯ-нд хүргүүллээ.

Мөн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт оюуны өмчийн мэдлэг олгох агуулгыг багтаах сургалтын хөтөлбөрийн төсөлд тусгах санал, төлөвлөгөөг урьдчилсан байдлаар боловсруулаад байна

[Зорилт-6 Байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх, санхүүгийн чадавх менежментийг сайжруулах зорилтын хүрээнд:](#)

Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар тус газраас “Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт”-д 1 Ахлах түшмэлийн багц сургалт”-д 1, “Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх дунд хугацааны сургалт”-д 1, “Төрийн албанд анх томилогдсон алба хаагчийг чиглүүлэх дунд хугацааны сургалт”-д 2 албан хаагч тус тус хамрагдаж төгслөө.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалтыг ил тод мэдээлэх зорилгоор Шилэн дансны цахим хуудсанд 81 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан. Үүнд: Бүтэн жилээр оруулах 4, хагас жилээр оруулах 3, улирал бүр оруулах 2, сар бүр оруулах 30, тухай бүрт оруулах нийт 42 мэдээлэлийг оруулаад байна.

Мөн Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого зарлагын гүйлгээг сар бүр оруулж, Шилэн дансны цахим хуудсанд 81 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан. Үүнд: Бүтэн



жилээр оруулах 4, хагас жилээр оруулах 3, улирал бүр оруулах 2, сар бүр оруулах 30, тухай бүрт оруулах 42 мэдээлэлийг оруулаад байна.

Оюуны өмчийн газрын 2023 оны зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг хянаж, шаардлагатай зардлыг санхүүжүүлэхээр төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг 4, 6 дугаар саруудад албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, 2023 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж санхүүгийн тайлангийн нэгтгэлд нэгтгүүлэн ажиллаж байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу үнэлэхэд Г гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1 дүгээр зорилт буюу “Оюуны өмчийн эрх зүйн орчныг Монгол улсын хөгжлийн шаардлага, олон улсын чиг хандлагад нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд төлөвлөсөн 2 арга хэмжээний хэрэгжилт -85%, 2 дугаар зорилт буюу “Бүтээл туурвих, шинийг санаачлах, үйл ажиллагааг дэмжих тогтолцоог боловсронгуй болгох” зорилтын хүрээнд төлөвлөсөн 7 арга хэмжээний хэрэгжилт -95,7%,

3 дугаар зорилт буюу “Оюуны өмчийн ашиглалтыг нэмэгдүүлэн үйлдвэрлэлд нэвтрүүлэх, оюуны өмчийн эрхийн хамгаалалтын чанарыг сайжруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах” зорилтын хүрээнд төлөвлөсөн 8 арга хэмжээний хэрэгжилт 100%, 4 дүгээр зорилт буюу “Байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг олон улс, бүс нутаг, гадаад орны түвшинд хөгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах” зорилтын хүрээнд төлөвлөсөн 5 арга хэмжээний хэрэгжилт 100%, 1 арга хэмжээний хэрэгжих хугацаа болоогүй байна.

5 дугаар зорилт буюу “Оюуны өмчийн мэдлэгийг нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах” зорилтын хүрээнд төлөвлөсөн 6 арга хэмжээний хэрэгжилт 95%, 6 дугаар зорилт буюу “Байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх, санхүүгийн чадавх менежментийг сайжруулах” зорилтын хүрээнд төлөвлөсөн 4 арга хэмжээний хэрэгжилт 100% тай байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлбэл:

Оюуны өмчийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний III улирлын хэрэгжилт 90,09 хувьтай бөгөөд 32 ажлын хэрэгжилтийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс (хувиар)							Хэрэгжилтийн дундаж хувь
	100	90	70	50	30	0	Хугацаа болоогүй	
32	27	-	3	-	-	-	2	90,09%



Оюуны өмчийн байгууллага нь 2023 гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 32 арга хэмжээтэйгээр төлөвлөн 90,09% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн ” гэсэн үнэлгээтэй байна.

Цаашид:

70% тай хувьтай дараахь 2 арга хэмжээг эрчимжүүлэн ажиллах;

- Төлөвлөгөөний 1.1.-т заасан Оюуны өмчийн биет бус хөрөнгийн үнэлгээний аргачлал боловсруулж, батлуулах;
- Төлөвлөгөөний 2.7.-т заасан Албаны хэрэгцээнд ашиглаж буй программ хангамжийг лицензжүүлэх зэрэг арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх;

Хугацаа болоогүй дараахь 2 арга хэмжээг ойрын хугацаанд төлөвлөн ажиллах. Үүнд:

- Төлөвлөгөөний 4.1-т заасан ОХУ-Монгол Улс-БНХАУ-ын оюуны өмчийн байгууллагуудын 11 дэх удаагийн уулзалт, зөвлөгөөнд оролцох;
- Төлөвлөгөөний 5,1-т заасан Оюуны өмчийн шилдэг бүтээл шалгаруулах зэрэг арга хэмжээ байна.

**ХОЁР. ОЮУНЫ ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ**

Оюуны өмчийн байгууллага нь 2023 онд байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан 6 зорилтын хүрээнд 32 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсан. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг 11 сарын байдлаар хэрэгжилтийг бид 90,09 хувьтай гэж үнэллээ.

Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчдын 44% нь эмэгтэй, 56% эрэгтэй байсан бөгөөд насны ангиллаар авч үзвэл 34% нь 18-25 насны, 24% нь 26-35 насны, 21% нь 36-45 насны, 21% нь 46-аас дээш насны хэрэглэгчид байна. Боловсролын түвшингээр авч үзвэл 2% нь бага болон боловсролгүй, 4% нь бүрэн бус дунд, 37% нь бүрэн дунд, 58% нь дээд боловсролтой байна. Судалгаанд оролцогчдын 49% нь төрийн байгууллагад ажилладаг, 16% нь оюутан, 10% нь хувийн хэвшил, 10% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 10% нь ажилгүй, 6% нь ТББ/ ОУБ-д ажилладаг иргэд байна.

Оюуны өмчийн байгууллагын бодлого үйл ажиллагаа, чиг үүрэг, гүйцэтгэл, хэрэгжилтийн үнэлгээ, үр дүнг 1-5 (1 бол Маш муу, 5 бол Маш сайн) оноогоор үнэлж, дундаж үзүүлэлтийг 3 байна гэж тооцсон.

Иргэдээс авсан судалгааны дүнг харвал үүргийн хэрэгжилтийн үр дүнд өгсөн үнэлгээ өмнөх оноос өссөн дүнтэй байна. Тухайлбал тус байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт 2,9-аас 3,0 үйлчилгээний түргэн шуурхай байдлын




дундаж үзүүлэлт 2,8-аас 2,9 хууль хэрэгжүүлэх үүргийн хэрэгжилтийн дундаж үзүүлэлт 2,8-3,0 болж тус тус өссөн дүн гарлаа.

Харин Оюуны өмчийн байгууллагын талаар хуульчдын зүгээс өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ иргэдээс өндөр байгаа нь салбарын мэдээлэлд илүү, ойр байдагтай холбон авч үзэж болох юм.

Зураг 7. Тус байгууллагын талаарх иргэдийн мэдлэг, сэтгэл ханамж, үйлчилгээний түргэн шуурхай байдал, хууль хэрэгжүүлэх үүргийн хэрэгжилтийг харуулбал:

	2022	2023
1. Байгууллагын талаарх иргэдийн мэдлэг, сэтгэл ханамж,	2.9	3.0
2. Үйлчилгээний түргэн шуурхай байдлын дундаж үзүүлэлт	2.8	2.9
3. Хууль хэрэгжүүлэх үүргийн хэрэгжилтийн дундаж үзүүлэлт	2.8	3.0

Үзүүлбэл:



Ерөнхий сэтгэл ханамж

Оюуны өмчийн байгууллагын үндсэн үйл ажиллагаа, мэдээлэл, шударга байдлыг 1-5 оноогоор (1 бол маш муу, 5 бол маш сайн) үнэлүүлсэн.

Оюуны өмчийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны талаар судалгаанд хамрагдсан иргэдийн 13% нь мэдэхгүй байна. Үндсэн үйл ажиллагаа, үүргийн талаар мэдэж байгаа иргэдийн сэтгэл ханамжтай байдлын түвшин дундаж хэмжээнд хүрэх хандлагатай байна. Аливаа төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд сэтгэл хангалуун биш, төрд итгэх итгэл суларсан нь судалгааны дүнд нөлөөлсөн байж болох учир энэ асуудлыг харгалзан үзэх ёстой болов уу.

Хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн бүүрсан үзүүлэлттэй гарсан боловч Мэдэхгүй гэх хариулт 2022 онд иргэдийн 8-11%-ийг эзэлж байсан бол 2023 онд 6-7% болж бүүрсан эерэг үзүүлэлт гарав.





Энэ хүрээнд тус байгууллагын үүргүүдийг иргэд 2,4-2,8 оноогоор үнэлсэн бол бусад байгууллагын албан хаагчид болон хуульчид иргэдээс арай илүүгээр буюу 2,8-2,9 оноогоор үнэлжээ. Үзүүлэлт тус бүрээр харвал:

- 1.Оюуны өмчийн байгууллагын үйл ажиллагааны залгамж холбоог иргэд 2,5,
- 2.Төрийн албан хаагчид, хуульчид 2,8
- 3.Ирсэн санал гомдолд хариу өгөх байдалд иргэд 2,7, ТАХ, хуульчид 2,9
4. Ажилтан албан хаагчдын харилцаа хандлагад иргэд 2,7, ТАХ, хуульчид 2,9
- 5.Үйл ажиллагааны шуурхай байдалд иргэд 2,6, ТАХ, хуульчид 2,8
6. Авлигаас ангид шударга ажиллаж буйд иргэд 2,4, ТАХ, хуульчид 2,8
7. Үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ техник технологийн дэвшил ашиглах байдалд иргэд 2,8, ТАХ, хуульчид 2,9
- 8.Чиг үүргээ хэрэгжүүлэхдээ холбогдох хүмүүст мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх байдалд иргэд 2,7, ТАХ, хуульчид 2,8
- 9.Хяналт үнэлгээ хийх байдалд иргэд 2,6, ТАХ, хуульчид 2,9 оноо өгсөн байна.

Авлигаас ангид, шударга ажиллаж байгаа (2.4), байгууллагын үйл ажиллагааны залгамж холбооны (2.5) үнэлж, техник технологийн дэвшлийг ашиглах байдалд иргэд, төрийн албан хаагч, хуульчид өндөр үнэлгээ өгсөн байна.

❖ *Төрийн үйлчилгээ бүрэн авсан байдал, хэдэн байгууллага дамжсан болох*





Судалгаанд оролцсон иргэдээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, албан хаагчдын харилцаа, ёс зүйн байдлыг 1-5 оноогоор (1 бол маш муу, 5 бол маш сайн) үнэлүүлж, дундаж үзүүлэлт 3 байхаар тооцож, үр дүнг дундаж үзүүлэлттэй харьцуулсан байдлаар гаргалаа.

Төрийн үйлчилгээний дурдсан 4 бүлэг асуудалд 2022 онд иргэд сэтгэл ханамжгүй буюу дунджаас доогуур гарч байсан бол 2023 оны судалгаагаар бүгд дунджаас дээш үзүүлэлттэй гарсан эерэг дүн гарлаа. Энэ нь 2022 онд хийсэн ажлын үр дүнг шууд харуулж байна.

❖ *Иргэд Оюуны өмчийн байгууллагаар үйлчлүүлсэн байдалд өгсөн үнэлгээ*

		Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн	Нийт
Чанар	Үйлчилгээний чанар	7%	13%	38%	39%	4%	100%
	Байгууллагын албан хаагчид асуудлыг нэг удаагийн хандалтаар шийдэж өгөхийг хичээддэг байдал	10%	17%	40%	29%	4%	100%
	Алба хаагчдын мэргэжлийн үр чадвар, мэдлэг	9%	15%	36%	34%	5%	100%
	Хариу мэдээлдэг байдал	13%	18%	37%	24%	8%	100%
	Санал, гомдол илэрхийлэх боломж нээлттэй байдал	11%	21%	34%	28%	6%	100%
	Хүртээмж	Та дээрх үйлчлүүлсэн байгууллагынхаа хүртээмж	6%	12%	45%	33%	4%
	Үйлчилгээний ачааллын хэвийн байдал	6%	13%	45%	32%	4%	100%
	[Үйлчилгээг хэрхэн авах, ямар материал бүрдүүлэх талаар энгийн, ойлгомжтой байдал	5%	18%	37%	34%	6%	100%
	Холбогдох үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай, ил тод байдал / самбар гэх мэт/	6%	18%	42%	28%	5%	100%
	Хандсан асуудлын хүрээнд шаардлагатай мэдээлэл зөвлөгөөг авах боломжтой байдал	6%	16%	41%	32%	5%	100%



Харилцаа, ёс зүй	Та дээрх үйлчлүүлсэн байгууллагынхаа алба хаагчийн харилцаа, хандлага	6%	15%	36%	35%	8%	100%
	Ажилтнууд надад туслахад бэлэн байдаг/хандлага/	8%	14%	39%	32%	7%	100%
	Ажилтнуудын эелдэг таатай харилцаа	8%	13%	39%	33%	8%	100%
	Ажилтнууд бүх үйлчлүүлэгчидтэй ижил тэгш харилцах байдал	8%	15%	38%	32%	6%	100%
	Ажилдаа хариуцлагатай ханддаг байдал	8%	10%	43%	31%	8%	100%
	Ажилтнуудын цаг баримтлах, ашиглах байдал	8%	16%	37%	31%	9%	100%
	Шударга байдал /гар харах гэх мэт/	7%	13%	40%	32%	9%	100%
Орчин нөхцөл	Та дээрх үйлчлүүлсэн байгууллагынхаа орчин	3%	12%	43%	36%	6%	100%
	Байгууллагын гадна болон доторх тэмдэг, тэмдэглэгээ харагдахуйц ойлгомжтой байдал	3%	13%	44%	33%	6%	100%
	Үйлчилгээний төвийн доторх үзгэн бал, маягт гэх мэт туслах зүйлсийн хүрэлцээ	3%	16%	43%	32%	7%	100%
	Хүлээлгийн танхим дахь ширээ, сандлын хүртээмж	4%	17%	41%	31%	7%	100%
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байдал	12%	26%	34%	21%	7%	100%

Иргэд төрийн үйлчилгээ, чанар хүртээмжийг сайнаар дүгнэсэн байна. Үйлчилгээ авсан иргэдийн үнэлэмж өссөн боловч төрийн үйлчилгээний чанар хүртээмж, өмнөх жилтэй харьцуулахад хэр ахицтай байгааг NPScore үнэлгээний аргачлалаар тооцож үзсэн болно. Оюуны өмчийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээг эерэгээр хүлээн авч байна.

Өмнөх онтой харьцуулахад 2023 онд гарсан ахиц дэвшил нь үйл ажиллагаа, үйлчилгээ сайжирсан, тус байгууллага нь үйл ажиллагаандаа техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж байгаа, Оюуны өмчийн байгууллагын алба хаагчдын харилцаа, хандлага сайжирсан, орчны тав тухтай байдал дээшилсэн тохилог болсон гэж иргэд үзэж байна.

2.1. Оюуны өмчийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, хүртээмжийн үнэлгээ, Хэвлэл, мэдээллийн чиглэлээр хийгдсэн ажлуудаас дурдвал:

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6-10 дугаар зүйл, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг тогтоох шалгуур үзүүлэлт”-ийн дагуу Оюуны өмчийн байгууллагын ил тод байдлын үнэлгээг хийхэд

Байгууллагын Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилсэн байх үзүүлэлтийг тайланд тусгалаа.



№	Байгууллага	Ил тод байдлын шалгуур үзүүлэлт, үнэлгээ хувиар 2022	Ил тод байдлын шалгуур үзүүлэлт, үнэлгээ хувиар 2023	Харьцуулалт
1.	Оюуны өмчийн газар	100	100	хэвийн
	ДҮН	100	100	1,4


Шинээр батлагдсан дүрэм журмыг цахим хуудаст тогтмол шинэчлэн нийт 47 мэдээллийг байршуулж, 5 видео шторк, 12 постер бэлтгэн нийтэд түгээсэн байна.

Оюуны өмчийн газрын цахим пэйж хуудсанд хандсан 235 иргэнд мэдээлэл зөвлөгөө, Монгол HD телевизийн “Оргил цаг” мэдээллийн хөтөлбөр, Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн “Өглөө” хөтөлбөрийн зочиноор тус газрын албан хаагчид оролцож Оюуны өмчийн эрхийн чиглэлээр олон нийтэд мэдээлэл хүргэсэн байна.

Дэлхийн оюуны өмчийн өдрийг тохиолдуулан WIPO, СУИС-тай хамтран Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн чиглэлийн сургалтын загвар хөтөлбөр батлах үүлзалтыг зохион байгуулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын мэндчилгээ, Оюуны өмчийн талаар ойлголт, мэдээлэл өгөх видео шторкийг Улаанбаатар дэлгэц, Лед интернэйшнл, Блүүберг ТВ, Централ молл худалдааны төвийн лед дэлгэц болон байгууллагын цахим хуудас, “Өглөөний сонин”-д нийтлүүлж олон нийтэд түгээсэн байна.

Олон нийтийг зохиогчийн эрх, хамаарах эрхийн мэдээллээр хангаж зохиогчийн эрхийн талаар сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах- Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн чиглэлээр Кино урлагийн зөвлөл, МУИС, Эрдэм их сургууль, Үндэсний номын сан, Улаанбааиар их сургууль зэрэг хуулийн этгээдүүдэд сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа тогтмол явуулж байна.

- **Оюуны өмчийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдал**



Тус байгууллагаар үйлчлүүлсэн иргэдээс “Таны үйлчлүүлсэн байгууллагын албан хаагчийн нэр, албан тушаал, хаягжилт гэх мэт мэдээлэл нээлттэй байсан уу?” гэж асуухад 56% нь “Зарим мэдээлэл байсан”, 36% нь “Тийм бүх мэдээлэл байсан”,




үлдсэн 8% нь “анзаараагүй” гэж хариулжээ.


Оюуны өмчийн байгууллагаас иргэд олон нийтэд зориулсан үйл ажиллагааг хэр зохион байгуулж байгааг 1-5 оноогоор үнэлүүлэхэд иргэд 2.1 оноо, төрийн албан хаагч, хуульч, шүүгчид 2.3 оноо буюу дунджаас доогуур үнэлсэн байна.

Нөгөө талаас иргэдийн идэвх оролцоог судалгаанд оролцсон иргэд, ТАХ, хуульчдын 50 гаруй хувь хангалтгүй, 10 хүрэхгүй хувь нь хангалттай гэж үнэлж байна.

Төрийн албан хаагчид хуульчдын үнэлгээ



Иргэдийн үнэлгээ





- Мэдээллийн эх сурвалж



Тус байгууллагын үйлчилгээний талаарх мэдээллийг телевиз болон цахим сувгаар авахаас гадна гар утасны апп хөгжүүлэх, ebarimt апп дээрээс авах, цахим үнэмлэхний бар кодыг ашиглан хүссэн мэдээлэл лавлагаагаа авдаг болох нь зүйтэй.

• **Хууль, дүрэм, журмын хэрэгжилтийн үнэлгээ**



Байгууллагын талаарх иргэдийн мэдлэг, сэтгэл ханамж, 1-5 оноогоор үнэлүүлэхэд 2.6 оноо буюу дундаас бага зэрэг доош үнэлсэн, *Үйлчилгээний түргэн шуурхай байдлыг*



иргэд 2.8, төрийн албан хаагч, хуульчид 3 оноогоогоор, *Хууль хэрэгжүүлэх үүргийн хэрэгжилтийн 3 оноогоор үнэлсэн* байна

ГУРАВ.ОЮУНЫ ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ХЭРЭГЛЭЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

3.1 Цахим хуудасны хүртээмжтэй байдал

Цахим хуудасны хүртээмжтэй байдлыг: Хэрэглэгч харилцаж болох байдал, цахим хуудасд байх мэдээллийн хүртээмжтэй байдлын үзүүлэлтээр хэмжиж үнэлсэн болно. Цахим хуудсанд өргөдөлийг авсан эсэх, хаана ямар шатанд явааг хянах боломжгүй байна. Цахим хэрэглээний хүртээмжийн хувьд үндсэн цэсний мэдээлэл шинэчлэгдэхгүй байгаа нь хэрэгцээтэй мэдээлэл авах боломжийг хязгаарлаж байна.

Байгууллагын зүгээс иргэдийг хүлээн авах хуваарь гаргасан ч хэдий ч хэдэн иргэн ямар асуудлаар хандсан талаарх мэдээлэл тодорхойгүй байгааг тайлагнаж байх.



Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР

ИРГЭДТЭЙ УУЛЗАХ ЦАГИЙН ХУВААРЬ

№	Нэрс	Гараг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
1.	Оюуны өмчийн газрын дарга Г.Элбэгсайхан <i>(Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой бүх асуудлаар)</i>			13 ³⁰ – 16 ³⁰			
2.	Захиргаа удирдлагын газрын дарга Д.Амгалан <i>(Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бүх асуудлаар)</i>		10 ⁰⁰ – 12 ³⁰				
3.	Аж үйлдвэрийн өмчийн газрын дарга С.Урангэрэл <i>(Аж үйлдвэрийн өмчийн эрхийн асуудлаар)</i>				10 ⁰⁰ – 12 ³⁰		
4.	Зохиогчийн эрхийн газрын дарга Н.Сүнжидмаа <i>(Зохиогчийн эрхийн болон түүнд хамаарах эрхтэй холбоотой асуудлаар)</i>					10 ⁰⁰ – 12 ³⁰	
5.	Хяналт, шалгалтын газрын дарга Л.Уянга <i>(Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны талаарх асуудлаар)</i>						10 ⁰⁰ – 12 ³⁰

-000-

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6.1.1-д заасан үйл ажиллагааны ил тод байдлыг байгууллагын тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлт, хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн мэдээллээр баяжуулж тэдгээрийг ил тод байлгах шаардлагатай юм. Иргэд харилцагч байгууллагууд хөндлөнгийн хяналт тавих боломжийг байгууллагын цахим хуудас хангахгүй байгааг өөрчлөх шаардлагатай байна. Дээрх хуулийн 7.1.2-т “үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас,



иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх” –ээр заасан байгаа. Энэ ажлыг хариуцсан хүнтэй байх шаардлага ч байна. Иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг тухайн байгууллагаас авах эрхтэй байдаг. Энэхүү иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаснаар төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг хэмжих шаардлага ч зүй ёсоор тавигдаж байна.

Цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдлыг: - өнгө, - хэлбэр загвар, - хэрэгцээтэй мэдээлэл олж авч болох эсэх гэсэн хэмжээсээр үнэлсэн болно. Хайлтын систем нь хэвийн ажиллаж байгаа бөгөөд цахим хуудасны өнгө, хэлбэр загвар нь хангалттай сайн байна.

Харин мэдээлэл ил тод нээлттэй байх, мэдээллийг хуульд заасан хугацаанд шинэчилж байх асуудал хэрэглэгчдэд хүндрэлтэй байдлыг үүсгэдэг байна.

Цаашид байгууллагын цахим хуудсанд байгаа мэдээллийг цаг тухайд шинэчилж, тусгайлан зохицуулсанаас бусад мэдээллийг ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах нь зүйтэй байна.

Байгууллагын цахим хуудсыг иргэд мэдээлэл авах үндсэн эх үүсвэр хэмээн үзэж, хөгжүүлэлт, сайжруулалт хийх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ:

Оюуны өмчийн байгууллагын 2023 оны “Хэрэглэгчийн үнэлгээ”-г Оюуны өмчийн байгууллагын үндсэн үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилтийн байдал болон бусад төрийн байгууллагуудын зүгээс иргэд олон нийтэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдал болон дээрх асуудлуудын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг 389 иргэдээс 70 орчим асуулт бүхий анкетын санал асуулга авч, төрийн албан хаагч, удирдах ажилтан экспертүүдтэй ярилцлага хийх замаар чанарын судалгаа, Оюуны өмчийн байгууллагын цахим хуудаст ажиглалтын судалгааг хийж гүйцэтгэв.

Харин Оюуны өмчийн байгууллагад хуульчдын зүгээс өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ иргэдээс өндөр байгаа нь салбарын мэдээлэлд илүү ойр байдагтай холбоотой юм.

Оюуны өмчийн байгууллагаар 2022 онд үйлчлүүлсэн иргэдийн 37 хувь нь хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадсан гэж хариулсан бол 2023 оны судалгаагаар 52 хувь болж өссөн байна. Үйлчилгээ авсан иргэд дээд тал нь 5 хүртэлх байгууллага дамжсан бөгөөд үйлчлүүлсэн иргэдийн 30 хувь нь нэг удаагийн хандалтаар, 39 хувь нь хоёр удаагийн хандалтаар, 26 хувь нь 3-4 удаагийн хандалтаар, 5 хувь нь 5-аас дээш удаагийн хандалтаар хүссэн үйлчилгээгээ авч дуусгасан байна.



Үйлчилгээний чанар хүртээмжийг NPPScore оноо иргэдийнх (-39%), төрийн албан хаагч, хуульчид (-46%) гарсан. Энэ нь үйлчилгээний чанар хүртээмжтэй холбоотой хийж байгаа ажил, гаргаж байгаа шийдвэрт шүүмжлэлтэй хандаж байгааг илэрхийлж байгаа бөгөөд гарсан алдаа дутагдалд иргэдийн 39 хувь харьяа агентлаг, байгууллагын албан хаагч, хуульч, шүүгчийн 46 хувь нь илүүтэй ач холбогдол өгч байна.

Эдгээрийг 3 бүлэг зорилтод багцлан тус бүрээр дүгнэж үзвэл:

- **Оюуны өмчийн байгууллагад өгсөн ерөнхий сэтгэл ханамжийн үнэлгээ**

Энэ хэсгийг бүхэлд нь дүгнэж үзвэл, Оюуны өмчийн үйл ажиллагаанд өгсөн ерөнхий сэтгэл ханамжийн талаарх үнэлгээ “хангалттай” хэмжээнд буюу **70%-иас 67.7%**-ийн үнэлгээтэй гарч байна.

- **Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, орчин нөхцөл, төрийн албан хаагчийн харилцааны соёл, ёс зүйн талаарх үнэлгээ**

Оюуны өмчийн байгууллагын үйлчилгээний орчин, нөхцөлийн нийлбэр дүн хамгийн өндөр буюу 3.9 гарсан. Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж, харилцаа, ёс зүй, орчин нөхцөлийг үнэлүүлэхээр 18 асуулт асуухад ганцхан “Байгууллагын гадна болон доторх таних, тэмдэг, тэмдэглэгээ, харагдахуйц ойлгомжтой байдал”-д иргэд сэтгэл ханамжтай байдал дунджаас дээгүүр гарсан нь **30%- ийн онооноос 26.8%** -ийн үнэлгээ авч байна.

- **Төрийн байгууллын мэдээлэл авдаг, авахыг хүсч буй сувгуудын сэтгэл ханамжийн байдал**

Төрийн мэдээллийг судалгаанд хамрагдсан иргэдийн 47% нь цахим хаягнуудаас, 35% нь телевизээс авсан байна. Иргэд төрийн байгууллагын мэдээллийг цахим орчин, цахим хуудас болон телевизийн сувгаар хүлээн авч байгаа бөгөөд энэхүү хоёр сувгаар төрийн байгууллагын мэдээллийг авах хүсэлтэй байна. Иргэд төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг мэдээлэл авах нэг суваг гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Эдгээрээс дүгнэж үзвэл салбарын нийт үйл ажиллагаа болон үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээ **67.7% + 26.8% = 94,5%** болж байна.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ:

Оюуны өмч нь бидний амьдралын чанарыг сайжруулж, эдийн засгийн өсөлтийг дэмжихээс гадна уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүч, хүнсний аюулгүй байдал, эрүүл мэнд зэрэг дэлхий нийтийн өмнө тулгарч буй бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд түлхэц болох инноваци, бүтээлч байдлыг дэмжиж байдаг онцлогтой.

Оюуны өмчийн газрын 2023 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, орчин нөхцөл, алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн



талаарх үнэлгээг хийлээ, Үнэлгээний нэгдсэн дүнгээр **94,5% 4,7** гэсэн оноотой “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үзүүлэлттэй байна.

Оюуны өмчийн газар нь 2023 онд төлөвлөсөн ажил үүргээ амжилтай хэрэгжүүлснээс гадна байгууллагын зүгээс иргэд болон аж ахуйн нэгж байгууллагад үзүүлдэг үйлчилгээг иргэд, төрийн байгууллага, хэрэглэгч нар үйлчилгээний талаарх сэтгэл ханамж өндөр үнэлгээтэй байна.

Цаашид 2021-2024 онд хэрэгжүүлэх Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан дараах бодлогын зөвлөмжүүдийг эрчимжүүлэн ажиллах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/22 тоот тушаалаар баталсан “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-нд заасан

1. Хүний эрх, эрх чөлөөг хангасан хүртээмжтэй хөгжилд түүчээлсэн дэд бүтцийг бэхжүүлэх зорилтын хүрээнд төлөвлөгдсөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж Оюуны өмчийн газрын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжийг сурталчилсан видео санамж, мэдээллийг дохионы хэлээр орчуулан олон нийтэд түгээх;

2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд төлөвлөгдсөн Оюуны өмчийн мэдээллийн сан бүрдүүлж хамгаалах, сурталчлах ажлыг идэвхжүүлэх;

3. Хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээр, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтын хүрээнд төлөвлөгдөн Эрх эзэмшигчдийн эрх ашиг хамгаалахад чиглэгдсэн олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох, Хоёр болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр шинэ төслийн санал боловсруулах, Оюуны өмчийн салбарын оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх, технологи, инновацыг дэмжих төвүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх зэрэг ажлуудыг эрчимжүүлэн ажиллах нь зүйтэйг зөвлөж байна.

СУДАЛГААНЫ БАГ

2023.10.22

